

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018.04.30

Улаанбаатар хот

Хурал 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 17:00 цагт “Хөнгөн бетон” ХК-ийн хурлын өрөөнд эхэлж 18:30 цагт дуусав. Хуралд нэр бүхий 6 хувьцаа эзэмшигч оролцов. Тооллогын комиссын дарга М.Буянхүү хувьцаа эзэмшигчдийн ирцийг танилцуулж саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийг танилцуулав.

Үүнд:

“Хөнгөн бетон” ХК-ийн зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцааны 179373 ширхэг хувьцаа ба ирсэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаа 177,154 ширхэг байгаа ба 99%-ийн ирцтэй байна. Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд зааснаар 50-иас дээш хувьтай гэж байгаа бөгөөд ирц 99%-тай байгааг хүчин төгөлдөр гэж үзэж хурлыг эхлүүлэв.

1. Б.Наранзул - 57399
2. Б.Наранцацралт - 26655
3. “Минжит булган гол”ХХК - 14918
4. Б.Наранзул / Т.Баярхүүгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч / - 1034
5. Н.Эрдэмбилэг -53842
6. Н.Эрдэмбаяр -23306

Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга Б.Наранзул хурлыг нээж үг хэлэв. “Хөнгөн бетон” ХК-ийн ээлжит хурлыг 2018.04.04-нд хийхээр зарласан боловч хувьцаа эзэмшигчдийн ирц бүрдээгүй учраас хойшлуулж, хойшлогдсон хурлыг өнөөдөр хийж байна. Ингээд “Хөнгөн бетон” ХК-ийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээснийг мэдэгдэе. Эхний ээлжинд хурлын дэгийг танилцуулъя. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрийг нь хэлэлцээд тус бүрд нь саналыг аваад шийдвэрлээд явах саналтай байна. Үүнтэй санал нэг байна уу?

Шийдвэрлэсэн нь: Өөр санал гаргаагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 %-ийн саналаар хурлын дэгийг батлав.

Б.Наранзул: Тооллогын комиссын дүнг авъя.

Асуудал 1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, дүгнэлтийг хэлэлцэж батлах.

Б.Наранзул: Та бүхэнд 2017 оны үйл ажиллагааны тайлангаа цаасаар та бүгдийн өмнө гаргаж тавьсан байгаа. Өнгөрсөн он манай үйлдвэр банкны зээлтэй холбоотойгоор маш хүнд байдалтай байлаа. Үйлдвэр эвдрэл гэмтэл ихтэй, ажиллах хүчин хангалтгүй байсан ба 4 сар гаруй хугацаанд үйлдвэрлэл явуулсан. 2017 онд 3514м³ блок үйлдвэрлэн борлуулж 404,1 сая төгрөгийн борлуулалтын орлоготой байлаа. Мөн өнгөрсөн онд эдийн засгийн нөхцөл байдал хүнд үргэлжилсээр байсан бөгөөд Мак ХХК, Дорнын цас ХХК зэрэг ижил бүтээгдэхүүн гаргадаг компаниудтай өрсөлдөхөд нилээн хүнд байсан, бид бүтээгдэхүүнээ хамгийн доод үнэ 110,000-115,000 төгрөгөөр зарж борлуулсан ба бартер солилцоогоор явуулж ирлээ. Цахилгааны зардал өссөн, ус, уурын үнэ нэмэгдсэн байгаа.

Б.Наранцацралт: Энэ жил үйлдвэрлэл дээр ажиллах хүчний хувьд ямархуу байв? 1м.куб блокны өөрийн өртөг хэд байна?

Б.Наранзул: Улс орны болоод барилгын салбарын эдийн засгийн нөхцөл муудаж үйлдвэрлэлийн захиалга эрс буураад байгаа ба үйлдвэрлэлийг 2017 онд мөн л 1 ээлжээр 4 сар л ажиллуулсан. Ер нь бол ажиллах хүчний зардал ихэсч байна, жишээ нь техник хэрэгслийн жолооч олдохгүй байна, ковш кран г-м техник хэрэгсэл мэргэжлийн хүн олдоц муутай байдаг. Энэ жил бид хорих ангиас ажиллах хүчин гэрээгээр 9 хүн авч ажиллуулахаар болсон. Бүтээгдэхүүний өртөг 93,000 орчим байна. Хүчин чадлаа нэмэгдүүлээд ахиухан ажиллавал өртөг буурах магадлалтай гэж үзэж байгаа.

Б.Наранзул: Та бүхэнд санхүүгийн тайланг хүргүүлсэн байгаа. 2017 оны борлуулалтын талаар би танилцуулчихлаа. Цахилгаан дулаан уур усны зардал жилээс жилд нэмэгдэж тогтмол зардал өсч байгаа нь үйлдвэрлэлийн хэмжээгээ ихэсгэхгүй л бол алдагдалтай ажиллахад хүргэж байна. Мөн засварын зардал нийт зардалд эзлэх хувь өндөр ба энэ нь сэлбэг хэрэгсэлийн олдоц муу, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж хуучирч элэгдсэнтэй холбоотой. Энэ жил бид бүтээгдэхүүнийхээ үнийг 125,000 болгосон байгаа. М700 маркаар тохирлын гэрчилгээгээ авах гэж байна. Хаусны эрэлт хэрэгцээ өссөний хирээр М700 маркийн хэрэгцээ шаардлага гарч ирж байгаа юм. Энэ жилдээ чадвал 15000м³ блок үйлдвэрлэхийг зорьж ажиллана. Нийгмийн даатгалд 171,0 сая, татварт 300,0-аад сая төгрөгний өртэй байгаа. Авлагатай компаниуд их байгаа.

Н.Эрдэмбаяр: Үйлдвэрлэлийн хүчин чадал хэд байдаг вэ? Энэ талаар.

Б.Наранзул: Автоклаваа бүрэн ашиглаж чадвал өдөрт 250м³ блок хийх боломжтой, жилд 44000м³ хийх хүчин чадалтай боловч улны тэрэгний эргэлт гүйцэхгүй, удааширалтай юм билээ. Манайх эргэлт удаан тул тэрэгний хүлээлт их үүсгэдэг. Нэг бол учиргүй их тэрэгний нөөцтэй байх, үгүй бол бүрмөсөн шинэчлэх хэрэгтэй болох юм. Гэвч шинэчлэхэд хүрвэл хөрөнгө мөнгө маш их орох тул одоохондоо боломжгүй, манай зам нь хүрэлцэхгүй юм байна лээ.

Н.Эрдэмбилэг: Ер нь тоног төхөөрөмжөө шинэчлэхэд хэд орчим хөрөнгө орох бол, урд хөршид бол байгаа байх даа, судалж үзэв үү? Бараг 10 дахин хямд тусах байхдаа, сая үзэсгэлэн болоод байсан.

Б.Наранзул: Германаас судалсан чинь 4 сая евро гэсэн байсан, их үнэтэй. Саяхан хятад руу явж Гуанжоу ороод судалж үзсэн, Дорнын цас ХХК-ийн блокны үйлдвэрийг угсарсан компанитай уулзсан. Зөвхөн зүсэх дамжлагаа шинэчлээд явбал болохгүй юм байхгүй лдээ. Шинэчлэхдээ хүрвэл хятад нь дээр л дээ.

Б.Наранзул: Сүүлийн 2 жил шахам хугацаанд зээлээ төлж чадахгүйгээс болж муу ангилалд орсон бөгөөд Хас банктай шүүхээр яваад сая эвлэрсэн. Үлдэгдэл дээрээ тохироод, ам.долларын зээлээ төгрөгт хөрвүүлэхээр тохиролцоонд хүрээд гэрээгээ байгуулсан байгаа. Одоо байгаа зээлийн үлдэгдэл болох 1,260,000 америк долларын зээлийг төгрөгт хөрвүүлэн долларын зээлийн хүү 395,000 ам.долларыг төгрөгийн зээлийн үлдэгдэл болох 333,323,870 төгрөгтэй нэгтгэн 5-аас дээш жилийн урт хугацаатай хүү нь 12 хувиас ихгүй эхний 12 сар үндсэн зээл төлөхгүй байх нөхцөлтэй банкны зээлэнд хөрвүүлэхээр тохиролцож чадсан. Долларын ханшийг тухайн өдрийн ханшаар хөрвүүлж, мөн хуримтлагдсан хүүгээсээ 691,0-аад сая төгрөгийг чөлөөлж хасуулсан. Эргэлтийн хөрөнгөд 600,0 сая төгрөгийн зээл аваад үүнээсээ үйлдвэрээ хөдөлгөж эхэлж байна.

Н.Эрдэмбаяр: Банктай хийсэн шинэ гэрээ нь байгаа юу?

Б.Наранзул: Байгаа, Хас банктай хийсэн шинэ гэрээтэй та нар танилцаж болно, хувилж өгье.

Б.Наранзул: Хуучин хэрэглээд сурчихсан газрууд манай блокыг хүлээж байгаа. Энэ жил бид блокоо харилцагчийн талбайд хүргэхэд замдаа үйрч бутарч хагардаг тул энэ тал дээр анхаарч блокоо поддон дээр тавиад бүслүүрээр бэхлэж тогтоож аппарат хятадаас авчирсан, энэ нь талбайд буулгахад, кранаар зөөхөд амар хялбар болсон. Өнгөрсөн жил

үйлдвэрийн хашаанд байгаа хоосон ашиглаагүй агуулах байраа өөр компанид түрээслэж байгаа, одоохондоо гүйцэд жигдрээгүй л байна.

Н.Эрдэмбаяр: Энэ жил үйлдвэрлэл оройтож эхлэх төлөвтэй байна уу?

Б.Наранзул: 3-р сарын 01-нээс хойш одоо болтол засвар хийгээд явж байна, монголд сэлбэг олдохгүй байна. Сая Гуанжоу-д очиж Резиний үйлдвэрээс автоклавын жийргэвч захиалж авчирлаа. Одоо шинэ төслүүд, ялангуяа Яармагийн төслүүдэд байршлын хувьд манайх ойр, боломжийн байгаа юм.

Бид өнгөрсөн жил асах их эвдэрч ажил зогсоосон сэлбэгүүдээ бүгдийг сэлбэж янзалж тавьсан, шинээр сэлбэг авч тавина гэдэг бол санхүүгийн хувьд хэцүү л дээ.

Н.Эрдэмбилэг: Хас банкнаас зээлээ саяхан авсан уу, ажил эхлэх бэлтгэлээ сайн базааж байгаа биздээ? Яармагт шинэ төсөл хэрэгжүүлэхэд оролцох хэрэгтэй байх шүү. Маркетингээ маш сайн хийх хэрэгтэй гэж бодож байна.

Б.Наранзул: Тиймээ, 4 сард зээл батлагдсан, энэ боломжийг зөв сайн ашиглаж, бэлтгэл ажлаа базаагаад явж байна.

Н.Эрдэмбилэг: Сайн ажиллавал энэ үйлдвэр ашигтай ажиллах боломж байгаа юм байна, тиймээс хамтраад ажиллах хүсэлтэй байна. Бид менежмент дээр чинь оролцъё, хамтаръя.. Гүйцэтгэх удирдлага, маркетинг дээр хүнээ оруулж ажиллах сонирхолтой байна.

Б.Наранзул: Одоохондоо учиргүй маркетинг хийх шаардлагагүй байхаа.

Н.Эрдэмбилэг: Сошиал маркетинг хэрэгтэй, компанийн зөв засаглал руу орж ажиллая, хүний нөөцөө анхаарах, вэбсайт, пэйж хуудас ажиллуулах гэхчилэн.

Н.Эрдэмбаяр: Хоорондоо ойлголцоод хамтраад явбал илүү үр дүнд хүрэх болов уу, харилцан бие биендээ туслалцах зэргээр, тэгвэл зүгээр гэж бодож байна.

Б.Наранзул: Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг батлах уу?

Шийдвэрлэсэн нь: Өөр санал гараагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 %-ийн саналаар батлав.

Асуудал 2. Ногдол ашиг хуваарилахгүй талаар танилцуулах

Б.Наранзул: Ногдол ашгийн тал дээр ЕСББ-ны болон ХАС банкны хамтарсан зээлээр аливаа өр зээлийг төлж барагдуулах хүртэл ногдол ашгийг хуваарилж төлөхгүй гэсэн зээлийн гэрээний үүрэг хүлээсэн учир ногдол ашиг хуваарилах боломжгүй угаасаа компани алдагдалтай ажиллаж байгаа.

Б.Наранзул: За ногдол ашиг хуваарилахгүй байх тал дээр банкны гэрээний үүргийн дагуу бүгд тэрийг ойлгож байгаа тул банкны өр зээл дуустал ногдол ашиг авахгүй.

Шийдвэрлэсэн нь: Өөр санал гараагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 %-зөвшөөрлөө.

Б.Наранзул: 2018 оны 4 дүгээр сарын 30-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын № 01 тоот “Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах, ногдол ашгийн тухай” тогтоолын төслийг хамтад нь танилцуулав.

Шийдвэрлэсэн нь: Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100% -ийн саналаар уг тогтоолын төслийг батлав.

Асуудал 3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

Б.Наранзул: Шинээр ТУЗ-ийн гишүүнд нэр дэвших хүний анкет 60 хоногийн дотор нэр дэвшүүлэх хүнийхээ анкетыг ирүүлсэн байх ёстой боловч энэ хугацаанд хувьцаа эзэмшигчдээс шинээр нэр дэвшигчийн материал ирүүлээгүй байна. Эрдэмбилэг, Эрдэмбаяр нараас ТУЗ-д нэр дэвшүүлэх хүнийхээ материалыг хуулийн хугацаанд нь багтаан ТУЗ-ийн нарийн бичигт ирүүлээгүй, хугацаанаас хожимдож мэдэгдсэн тул энэ

удаагийн хурлаар нэр дэвшүүлэх боломжгүй байгааг та хоёр ойлгосон байх. Тиймээс бид өмнөх 9 гишүүдээ улируулан сонгохоор оруулж ирж байгаа юм. Та бүхэн анкеттэй нь танилцана уу. Анкетыг танилцуулав.

Тошил овогтой Баярхүү ердийн гишүүнд
Баярхүү овогтой Наранзул ердийн гишүүнд
Баярхүү овогтой Наранцацралт ердийн гишүүнд
Болд овогтой Батбаяр ердийн гишүүнд
Бат-очир овогтой Эрдэнэбаяр ердийн гишүүнд
Баасанжав овогтой Алтанцэцэг ердийн гишүүнд
Алтангэрэл овогтой Мөнхзул хараат бус гишүүнд
Шаравсамбуу овогтой Энхтөр хараат бус гишүүнд
Янжив овогтой Хүрэлхүү хараат бус гишүүнд сонгохоор санал оруулж байна.

Н.Эрдэмбилэг: Харин тийм байна лээ. Энэ хувьцаа эзэмшигчдийн хурал дээр саналаа түдгэлзүүлье. Ээлжит бус хурал дээр шинээр нэр дэвшүүлэх саналаа хүргүүлье.

Н.Эрдэмбаяр: Ер нь бол бид ТУЗ-д 4 хүнээ оруулах саналтай байгаа, гүйцэтгэх захирал ч юм уу, маркетинг тал дээр.

Б.Наранзул: Дараагийн ээлжит бус хурлаар ч юм уу шинээр нэр дэвшүүлэх хүнээ санал болгож анкетийг ирүүлж болно, та нарт бол саналаа нээлттэй хэлэх бололцоо бол байгаа шдээ. Ерөнхийдөө хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлана, түүгээр өрийг хувьцаагаар солих уу, эсвэл компаниудын өр төлбөрийг яаж зохицуулах уу, танай зүгээс юу санал болгох боломжтой юм гэх зэргээр нээлттэй ярилцаж, хамтарч ажиллах боломжтой байвал бидний зүгээс татгалзах зүйлгүй.

Н.Эрдэмбаяр: Энэ жилийн ажлын төлөвлөгөө тодорхой байгаа юм байна. Ямар ч байсан бид дараагийн ээлжит хурал дээр ТУЗ-д нэр дэвшүүлэх хүмүүсээ санал тавья гэсэн саналтай байна.

Б.Наранзул: Та хоёр саналаа нээлттэй хэлэх хэрэгтэй, бид та хоёрын сайн таньж мэдэхгүй байгаа. Энэ жилдээ орон тоо, бүтцээ цомхон байлгаж ажиллах хэрэгтэй байгаа, учир нь банкны өндөр зээлтэй учраас, ажиллах хүч, орон тоон дээр цомхон байх нь зөв гэж бодож байгаа. Учиргүй маркетинг, PR хийхэд мөнгө хөрөнгө хүн хүч гаргах хэрэг байна уу, 4-5 байнгын харилцагч нартай гэрээ хийсэн байхад гол юм нь чанартай бүтээгдэхүүнийг хэлсэн хугацаандаа нийлүүлэх л гэж үзэж байна. Маркетингийг сошиалаар явуулж, фэйсбүүк пэйж нээж сурталчилгаа явуулах нь зүгээр байх гэж бодож байна.

Н.Эрдэмбилэг: Менежментээ яаж сайжруулах юм, компанийн зөв засаглалтай байх тал дээр саналаа солилцёе, ялангуяа вэб сайт, сошиал маркетинг, джитал маркетингийг ашиглах хэрэгтэй тэр чиглэл рүү анхаарах, хооронд яаж ажиллах талаар ярилцах л хэрэгтэй гэж бодож байна.

Б.Наранзул: ТУЗ-ийн ердийн гишүүн ба хараат бус гишүүнийг куммулятив аргаар сонгоно, нэр дэвшсэн хүмүүст өгөх саналын тоогоо өгөөд саналаа хураая. /Саналын хуудсаа тараав./

Тооллогын комисс саналын хуудсуудыг авч нэгдсэн дүнгээ гаргаад нэр дэвшсэн хүмүүст өгсөн саналын тоог гаргаад танилцууларай.

Тооллогын комиссын дарга М.Буянхүү: ТУЗ-ийн ердийн гишүүн ба хараат бус гишүүн сонгох саналын дүнг танилцуулав.

Д/д	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо
1	Баярхүү овогтой Наранзул	100,006
2	Баярхүү овогтой Наранцацралт	100,006
3	Тошил овогтой Баярхүү	100,006
4	Болд овогтой Батбаяр	100,006
5	Бат-очир овогтой Эрдэнэбаяр	100,006
6	Баасанжав овогтой Алтанцэцэг	100,006

д/д	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо
1	Алтангэрэл овогтой Мөнхзул	100,006
2	Шаравсамбуу овогтой Энхтөр	100,006
3	Янжин овогтой Хүрэлхүү	100,006

тус тус саналыг авч, 2 хувьцаа эзэмшигч түдгэлзсэн санал өгч, 4 хувьцаа эзэмшигчийн нийлбэр 100,006 саналын эрхийн тоогоор ТУЗ-ийн гишүүнээр сонгогдлоо.

Б.Наранзул: 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын №02 тоот тогтоолын төслийг танилцуулав.

Шийдвэрлэсэн нь : Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 56% -ийн саналаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох тогтоолын төслийг батлав.

Асуудал 3. Өрийг хувьцаагаар солих тухай

Б.Наранзул: Өрийг хувьцаагаар солих тухай асуудлыг энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж чадахгүй болсон. Учир нь Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлтэй үнэлгээний аудитын компаниар хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн тохиолдолд хурлаар хэлэлцэх ёстой юм байна, энэ нь их өндөр төлбөртэй ажил байсан тул мөнгө санхүүгийн хувьд боломжтой болсоны дараа ээлжит бус хурлаар хэлэлцье гээд хойшлуулж байгаа юм.

Б.Наранзул: За ингээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хаасныг мэдэгдье.

Тэмдэглэл хөтөлсөн:

Б.Ундрах

Тэмдэглэлтэй танилцсан:

Б.Наранзул

Б.Наранцацралт

“Минжит булган гол” ХХК
/Итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Наранзул/

Т.Баярхүү
/Итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Наранзул/

Н.Эрдэмбаяр

Н.Эрдэмбилэг

